

**ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ  
ТАЛААР НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 11 дүгээр  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн  
3.Баянсэлэнгэ**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд 2014 оны 10 дугаар сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2014 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөлд хоёр наснаас өрөнхий боловсролын сургуульд элсэх хүртэлх наслы хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд харах үйлчилгээг зохион байгуулах харилцааг зохицуулахаар тусгажээ. Хүүхэд харах үйлчилгээнд албан ёсны стандартад суурилсан боловсрол, сургалтын бус хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн хөгжлийг дэмжсэн нийгмийн халамж, хамгааллын тогтвортой үйлчилгээг бий болгох, төрийн санхүүжилт зориулалтын дагуу хүүхэддээ хүрч, үр дүнтэй зарцуулагдах нөхцөлийг бүрдүүлэх зарчмыг баримталсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар бага наслы хүүхдийн эсэн мэнд амьдрах, хамгаалагдах, хөгжих эрхийг хангах, хүүхэд бүрт төрөөс үзүүлж буй үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ, цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдэд төрөөс олгож буй санхүүжилтийг адил тэгш боломжтойгоор хүртээх, эцэг эх, асран хамгаалагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, өрхийн орлогыг нь нэмэгдүүлэх, цэцэрлэгийн өнөөгийн хэт ачааллыг бууруулах ач холбогдолтой гэж төсөл санаачлагч үзжээ.

Төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар хүүхэд харах төвийн зохион байгуулалтын төрөл, хэлбэр, үйлчилгээнд хамрах хүрээ, холбогдох яамдын үүрэг, оролцоо, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуультай хэрхэн уялдсан талаар, Улсын Их Хурлын гишүүн 3.Баянсэлэнгэ нийгэмд хүлээлт үүсгэсэн хуулийн төслийг өргөн мэдүүлсэнд талархал илэрхийлээд хүүхэд харах үйлчилгээнд хүүхдийг хоёр наснаас эхлэн хамруулж байгаа нь үндэслэлтэй эсэх, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах явцад гарч байсан зөрчилтэй зүйл, заалтыг хэрхэн тусгасан, хүүхэд харах ажилтны боловсролын түвшин, сургалтанд хамрагдалт, хувиараа цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулж буй багш нарын саналыг хэрхэн тусгасан, хүүхэд харах үйлчилгээнд зарцуулагдах төсвийг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын багцад суулгасан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээс гаргасан саналд хүүхэд харах үйлчилгээ тусгагдсан эсэх талаар асуулт асууж хариулт авлаа.


Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ.

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Д.БАТЦОГТ